



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



MPA.GOV.MN
ТӨГСЖИ ХАМГААГАЛТЫН ХАЗАР УЛУГИЙН СӨГӨӨ



МОНГОЛ ТАРВАГА



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



MPA.GOV.MN
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ



Энэхүү гарын авлагыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн буцалтгүй тусламжаар Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай хамтран хэрэгжүүлж буй “БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ”-МОН/13/303 төслийн хүрээнд бэлтгэн монгол орны үнэт баялаг Монгол тарвагыг сонирхсон хүмүүст зориулан хэвлүүлэв.



МОНГОЛ ТАРВАГА

Товхимлын бичмэл эхийг бэлтгэсэн:

Я.Адъяа, Э.Энхмаа

Гэрэл зургийг:

Я.Адъяа, Б.Отгонбаяр

Хэвлэлийн дизайнер:

Ц.Наранбат

Хэвлэсэн газар:

Наруддизайн ХХК

Улаанбаатар хот

2016 он



ӨМНӨХ ҮГ

Манай оронд алтайн болон монгол хэмээх хоёр зүйлийн тарвага бий. Тарвага нь ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд өргөн тархсан бөгөөд газрын өнгөн давхрааг сийрэгжүүлэн хольж хөрсний бүрдэл бүтцийг сайжруулж, ургамлан нөмрөгт асар их эерэг нөлөөг үзүүлдэг төдийгүй бүх мах идэшт хөхтөн амьтад, шувуудын идэш тэжээл болдог ач холбогдолтой. Өвсөн тэжээлт энэ мэрэгч нь идэвх хөдөлгөөний ид үедээ ч мал, зэрлэг амьтны бэлчээрийн өвс ургамлыг булаах, хороох сөрөг нөлөөгүй.

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 60 гаруй хувьд тарвага байршин амьдрах боломжтой юм. Олон жил дараалан бүлийн хэвийн үржил, нөхөн төлжилтийг тооцолгүй эрчимтэй агнасан, тархац нутгийн зарим хэсэгт газар хагалж тариалан эрхэлсэн, тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сийрэгжүүлэх агналт, устгал их хэмжээгээр хийсэн, дэлхэц нутгийн ихэнх хэсэгт ган болж, тарга тэвээрэг муу авч өвөлжихөд шаардлагатай энергийн нөөц өөхөн давхаргыг хуримтлуулж чадахгүй өвөлдөө ичээ нүхэнд үхэх зэрэг нь тарваганы тоо толгой буурах, тархац нутаг тасархайтан хумигдах үндсэн шалтгаан болжээ.



Монгол орон тарваганы баялагаа зөв зохистой хаягдалдалгүй, ашиглаж чадвал улс орны эдийн засаг ард түмний амьжиргаанд багагүй нэмэр болох үнэт баялаг мөн болохыг хүн бүр дээр доргүй мэдэх атлаа эцэг өвгөдөөс үе дамжин өвлөгдөн ирсэн хайрлан хамгаалах уламжлалаа мартан гээж, хомхой сэтгэлээр хандах ихэссэн нь бидний нэгэн “эмгэнэл” билээ.

”Ашиглавал хамгаалдаг” зарчмыг тарвага агнуурт баримтлах, эдийн засгийн арга механизмыг төлөвшүүлэн тогтооход төрийн бодлого, олон нийтийн байгууллагын чармайлт, иргэн бүрийн идэвхи санаачлага хэрэгтэй байна.

Монгол орны хөхтөн амьтны зүйлийн бүрдлийг хэвээр хадгалан хамгаалахад олон хүндрэлтэй асуудлууд тулгарч буй хэдий ч байгаль хамгаалах иргэдийн идэвх нэмэгдэж, олон байгууллага, нөхөрлөл үүсч хамгаалал, судалгааны үйл хэрэгт нутгийн захиргаа, иргэд хувь нэмрээ оруулж байгаа нь сайшаалтай.

Үндэсний үнэт баялагын нэг Монгол тарваганы тухай шинжлэх ухааны үндэстэй танин мэдэхүйн ач холбогдолтой бага боловч мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх нь энэ зүйл амьтан төдийгүй нийт зэрлэг амьтныг хайрлан хамгаалах, зохистой ашиглах аргад суралцахад тустай хэмээн энэхүү гарын авлагыг бэлтгэн нийтлүүлж байна.

ТАРВАГАНЫ ГАДААД ТӨРХ

Нас бие гүйцэж, хүч тарга гүйцэд авсан Монгол тарваганы биеийн жин ойролцоогоор 10 кг, биеийн урт 65 см хүрнэ. Үзүүр хэсэг нь бараан 90–160 мм урт сүүлтэй хадны ангал, нүх хөндий, ганга налууд чадмаг авирна. Толгой тавшгар, дагз хар, хүзүү богино, чих хулгар, хөдөлгөөн болхи амьтан. Нүд нь гавал ясан дээр байрлалтай тул нүхнээс цухуймагц орчны байдлыг ажиглан харах чадвартай болжээ. Үнэр, харааны эрхтэн сайн хөгжсөн. Шанаа, хоншоор, эрүү, нүдний орчим байх 3–6 см урт олон тооны мэдрүүл үс нь харанхуй нүхэнд орж, гарахад мэдээлэл өгөх гол үүрэг гүйцэтгэнэ. Мөчид хүчирхэг, урд мөч тав, хойд мөч дөрвөн хуруутай. Хумс бахим, мохоо, хүчирхэг.





НАС, ХҮЙС

Агнуурын нөлөө ихтэй манай орны хувьд байгалийн популяци дахь Монгол тарвага дунджаар 10 орчим жил амьдарна. Монголчууд тарваганы нас, хүйсийг сайтар ялган танихын зэрэгцээ тухайн нас, хүйсний биологийн өвөрмөц онцлогт нь тохирсон оноосон нэрийг хэрэглэнэ. Тухайн жилийн төлийг “мөндөл”, дөнгөж гадаалсныг “эргүү цагаан”, нэг удаа өвөлжсөнийг “хотил”, хоёр өвөлжсөн “шар хацар”, гурав дахь өвөлжилтөөс бие гүйцсэн хэмээн үзэж эрийг “бурхи”, эмийг “нагай” төллөөгүйг “сувай тарч” гэнэ.

Эр, эм хүйсийг хялбар ялгах гол шинж нь тарчны шулуун гэдэсний төгсгөл, хүйсний нүх хоёрын хоорондох зай бурхинаас хоёр дахин бага байна.

ТАРХАЦ, БАЙРШИЛ

Ази тивд ойролцоогоор 25 сая жилийн өмнө өнөөгийн тарваганы өвөг амьдарч байсныг гэрчлэх палентологийн олдворууд бий. Монгол орны хувьд Улз голын баруун эрэгт 5–6 мянга, Дундад халхын өндөрдлөг, Дарьганга орчимд 7–8 мянган жилийн өмнө тарвагатай байсныг тогтоосон.

Манай оронд алтайн тарвага (*Marmota baibacina*), Монгол тарвага (*Marmota sibirica*) хэмээх хоёр зүйл тарвага тархсан. Монгол тарвага манай орны уулын хээрт зонхилж хойт талын хөвч тайга, урд талын говь цөлийн бүс хүртэлх уудам зурвас нутагт далайн түвшнээс дээш 800–3800 м өндөрт тохиолдоно. Төв азийн эрс тэс хуурай уур амьсгал бүхий өвөрмөц экологи, нөхцөлтэй Монгол орны умард өргөрөгийн 44°–52°, уртрагийн 90°–120° хооронд тархан байршихдаа умард өргөрөгийн 45°–50° илүү ихээр идээшин зохилджээ.



Монгол тарвага манай улсын хилийн гаднах Байгалийн зүүн өмнөд хэсэг, Буриад, Тува улстай хил залгаа нутаг Манжуурт нэвтэрчээ. Тархац нутгийн хойд хэсэгт уул нуруудын ой модгүй өмнөд, баруун өмнөд энгэр, өвөрт байршдаг бол тархцын урд захын хуурай хээрийн бүсэд уулын арын сүүдэртэй, арай чийглэг нутагт зонхилон байршин амьдардаг ерөнхий зүй тогтол ажиглагдана.

Монгол тарвага өндөр уулын тагийн, уулын тайгын бүслүүр, цөлөрхөг хээрийн бүсийн зах руу лав түрэн орсон байх нь элбэг тохиолддог. Ой сөөгтэй, харууц муутай, чийг ихтэй, намгархаг газраас зайлсхийх авч сийрэг ойн зах түрэн, мөнх цэвдэг, хөрсний ус ойр газарт хөрсний өнгөн хэсэгт нүх малтан амьдрах нь цөөнгүй.




БҮЛ, БҮЛИЙН ЭЗЭМШИЛ НУТАГ

Тарвага бүл, нутаг бүл (колони) үүсгэн амьдарна. Идэшлэх талбай, ичээ, зусаал, муу нүх, газар нутгаа хамтран эзэмшиж, тоо толгойгоо бүлийн дотор зохицуулан үрждэг, бүлийн гишүүдээ ялган таньдаг, янз бүрийн нас, хүйсний 2–оос дээш толгой хэсэг бодгалийг нэгэн бүл хэмээн тодорхойлж болно. Ураг төрлийн холбоогүй өөр бүлээс янз бүрийн нас, хүйсийн тарвага тухайн бүлд шилжин нийлж болно.

Хараа, дуу авианы мэдээ дохиололыг өөр хоорондоо чөлөөтэй дамжуулах боломжтой харьцангуй тусгаар 3–100 хүртэл бүлийг колони буюу “бүл нутаг” гэж ойлгоно.

Бүл тус бүр дайсан амьтдаас биеэ хамгаалан түр орогнох, үржих, төрөх, өвөл ичээлэх зориулалт бүхий олон нүхтэй, хавар зун намрын турш хүрэлцэхүйц хэмжээний идэш тэжээлийн нөөц бүхий эзэмшил нутагтай байна.

НҮХНИЙ БҮТЭЦ, БАЙГУУЛАМЖ



Тарвага нүхэнд орж дайсан амьтад, цаг агаарын тааламжгүй нөхцөлөөс биеэ хамгаална. Мөн нүхэнд эвцэлдэж, үр төлөө бойжуулна. Тарваганы нүхийг бүтэц, зохион байгуулалт, ашиглах хэлбэрээр нь муу нүх, зусаал нүх, ичээ нүх хэмээн ангилж болно.

Муу нүх нь гэнэтийн аюул тохиолдох мөчид түр хоргодох зориулалттай, бүл, колонийн эзэмшил нутгийн захаар байрлах харьцангуй энгийн бүтэцтэй, ноохойн тогоогүй, ихэвчилэн нэг амтай, нүхний сум нь дунджаар 1.5–7 м, хөрсний 1 м орчим гүнд байрлана. Зуны халуунд эрэгний мухар, хадны хөндийд ухсан богино, мухар нүхэнд түр орогноно.

Бүтэц зохион байгуулалт нь ичээ нүхнээс энгийн, дулаан хадгалалт муутай, харин эзэмшил нутгаа бүрэн ашиглах, гарч идэшлэх, дайсан амьтдаас биеэ хамгаалах түр орогноход тохиромжтой олон амтай нүхийг **зусаал нүх** гэнэ. Ийм хэлбэрийн жинхэнэ ноохойн тогоогүй голдуу 1.7 м-ээс илүүгүй хэмжээтэйгээр хөрсний гүнд хонгил нүхийг малтсан, олон амтай, хоорондоо дөр нүхэнд зусаж, намаржина.

Ичээ нүх 1–3 м орчим хөрсний гүнд 0.2–1.2 м³ багтаамжтай, нэг ба хэд хэдэн ноохойн тогоотой, хэдэн арван метр урттай хонгил нүхнээс бүтнэ. Ичээ нүхний амсраас 0.5–2.1 м хол зайд баруун, зүүн тийш салсан 0.6–2.3 м урт, хавар ичээнээс гарснаас хойш ичих хүртлээ ялгадсаа хураадаг мухар нүх буюу баасны өхтөө бий.

Ичээ нүхийг ашиглах хэлбэрээр нь төрөх, өвөлжих, зусах хэмээн ангилна. Олон амтай ичээ нүхэнд тарвага ичихдээ нэг амыг онгорхой үлдээж бусдыг гаднаас нь шороо чулуугаар дарна. Үлдсэн нэг амыг дотроос нь баасны өхтөөнд хуримтлуулсан өтгөн ялгадсаа шороо, чулуутай хольж буюу дан шороо чулуугаар нягтруулан шахаж бөглөнө.

Үүнийг ихэнх нутагт ичээ түлхэх, ичээ нүхний бөглөөг “ичиг” гэнэ. Ичигний урт 2.5–9.5 см хүрнэ. Тарвага ичээлэхэд бэлтгэн нүхэндээ 2.3–5.2 кг хуурай өвс “ноохой” зөөж хураана. Ноохойн өвсийг идэш тэжээлд хэрэглэдэггүй харин дулаалга маягаар ашиглана. Ноохойг “дэвсгэр”, “хучлага” маягаар засна.






ИДЭШ ТЭЖЭЭЛ

Монгол тарвага чийгийн агууламж ихтэй 80 гаруй зүйл ургамлын боловсорч гүйцээгүй үр, шинэхэн навч, нахиа, цэцэг зэрэг түргэн боловсордог, шингэц сайтай хэсгийг сорчлон таслан иддэг онцлогтой. Үхсэн мал, амьтны сэг зэм, яс мэрэх нь тохиолдоно. Бие организмд шаардлагатай усныхаа хэрэгцээг идэш тэжээлийн ургамалд агуулагдах чийгээр нөхнө. Харин хавар эрт, намар орой өвс ургамал хатаж, гандсан, идэш тэжээлийн ургамал дахь чийгийн агууламж багассан үед цас идэх, горхины ус уух нь бий. Тэжээвэр нөхцөлд тогтмол ус хэрэглэнэ.

Монгол тарвага VII сарын сүүлээс эхлэн эрчимтэй тарга, тэвээрэг хуримтлуулан ичээлэхэд шаардлагатай энергийн нөөц өөх хуримтлуулна. Нас бие гүйцсэн бодгаль 0.9–1.3кг өөхийг намар ичих болтлоо хуримтлуулдаг байна. Ердийн өөхнөөс олон дахин их исэлдэх чадвартай, бага дулааны хэмд задарч их энерги ялгаруулдаг, өвөрмөц чанартай “хүн мах” хэмээн нэрлэдэг “бор өнгөтэй өөх” Монгол тарваганд бий. Тарваганы “хүн мах” хүзүү, далны дээд хэсэг, эгэмийн дагуу бага хэмжээгээр гол хэсэг нь суганы хонхорт цээжний хэргэр булчин, далны хуудас хоёрын завсар байрлана.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


Тарвага нүх ухаж, орчны хөрс ургамалд тодорхой үр дагавар бүхий шууд болон дам нөлөө үзүүлнэ. Монгол тарвага, цайвар үлийч, дагуур огдой зэрэг амьтдын нөлөөгөөр тухайн газрын хөрс сийрэгжин, байраа сольж, чийг, агаарын солилцоо эрчимжиж, эрдэс, шим бодисоор баяжин, дошин дээрх ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгддөг болохыг судлаачид тогтоосон. Идэш тэжээл хомсдолтой хаврын улиралд тарвага ихэвчлэн ургамлын үндэс, ухаж идэшлэхдээ олон жижиг хонхорууд үүсгэхээс гадна эзэмшил нутгийн хилийг тэмдэглэн газар хонхойлно.



Тарваганы ялгадас, сэг зэм нь задарч хөрсийг тогтмол бордохоос гадна ноохойн тогооноос нүхний гадна зөөж гаргасан ургамлын үлдэгдэл хөрс бордоно.

Тарвага хөрсний өнгөн хэсгийг малтах, органик бодисоор хөрсийг баяжуулах замаар ургамлын ургацад эерэг нөлөө үзүүлдэг. Хөрс нь "сайжирсан" тарваганы дошин дээр олон зүйлийн ургамал, өтгөн өндөр ургаж ургамлан нөмрөг үетэн, буурцагтан элдэв өвст ургамлаар солигдох бөгөөд энэ нь улирлаар харилцан адилгүй байх зүй тогтолтой.

Монгол тарвага хээрийн экосистемийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн бөгөөд байгалийн бүх амьдас (бусад амьтан, ургамлын аймаг, хөрс гэх мэт) болон амьгүй эрхэстэй (ус, эрдэс, агаар, нарны цацраг, цаг уурын үзэгдлүүд гэх мэт) байнгын харилцан холбоо шууд болон дам хамааралтай шүтэлцэн амьдрах нарийн зүй тогтолтой байна.



ҮРЖИЛ



Тарваганы үржилд үржлийн хос үүсгэх (моногам), нэг бурхи олон тарч хээлтүүлэх (полигам) хэлбэрийн аль аль нь буйг судлаачид тэмдэглэдэг. Монгол тарвага хавар ичээнээс сэрмэгц ороо хөөцөөнд орно. Шар хацар наснаас эхлэн тарч хээл авч, 30–35 хоног тээж дунджаар 5–7 зарим тохиолдолд 12 хүртэл мөндөл төрүүлнэ. Үржилд орсон тарчны ихэнх хувийг 4–7 насны бодгалиуд эзэлдэг бөгөөд 10 нас хүртэл үржих чадвартай.

ИДЭВХ, ХӨДӨЛГӨӨН




Тарвага идэшлэх, тоглох, нарлах, бүлийн эзэмшил нутгийн хил хязгаарыг тэмдэглэн амьдралын шаардлагатай орон зайн бүтэцээ тогтоон эзэмших, ичээ ноохойгоо засаж ичихэд бэлтгэх зэрэгт зарцуулах хугацаа улиралаар өөрчлөгдөх боловч дунджаар 5–7 цаг нүхний гадна байж үлдсэн бүх хугацааг нүхэнд өнгөрүүлнэ. Түүнчлэн цаг агаарын тааламжгүй, хүйтний улиралын 6 сар орчим хугацааг тарвага ичээлж өнгөрүүлнэ.

Энэ нь амьдралынхаа 85 орчим хувийг хөрсний гүнд малтсан нүхэнд өнгөрүүлдэг гэсэн үг юм. Ичээнд орсон бодгалийн биеийн температур, амьсгалах хэмнэл, зүрхний цохилт эрс буурч, бодисын солилцооны эрчим хэд дахин багасдаг. Ичээлэх үзэгдлийн мөн чанар нь хүйтний улиралд энергийн зарцуулалтыг хэмнэхэд оршино.

ДАЙСАН АМЬТАД



Тарваганд олон төрлийн мах идэшт хөхтөн, шувууд дайсагнана. Манай орны хувьд тарваганы хамгийн гол дайсан бол саарал чоно (*Canis lupus*), гэрийн нохой (*Canis familiaris*) болно. Хэвлэлийн мэдээ баримт, ажиглалт судалгаанаас харахад цоохор ирвэс (*Uncia uncia*), хүрэн баавгай (*Ursus arctus*), шар үнэг (*Vulpes vulpes*), хярс үнэг (*Vulpes corsac*), эрэн хүрэн (*Mustela eversmanni*) зэрэг мах идэшт амьтад мөн дайсагнадаг. Шар үнэг, хярс үнэг, өмхий хүрэн зэрэг махан идэшт амьтад мөндөл, өвчтэй бодгалийг түлхүү барьж иднэ. Өмхий хүрэн намар тарвага ичсэнээс хойш ичээг цоолон барьж идэх нь цөөнгүй тохиолддог. Чоно, нохой тарвага барихдаа салхи дэвсэн гэтэж ойртох буюу нүхнээс холдсон үед нь гэнэт довтолж барьдаг. Бас түүний үхдэл, зэмээр хооллоно.



Цармын бүргэд (*Aquila chrysaetos*), тарважи бүргэд (*Aquila rapax*), нөмрөг тас (*Gyps himalayensis*), шилийн сар зэрэг махчин шувууд мөндөл, сул дорой хөгжилтэй болон өвчтэй бодгалийн гол дайсан болдог.

Тарвага дайсан амьтад хараад болон айж, цочих үедээ тодорхой мэдээллийг агуулсан янз бүрийн давтамжтай дуу авиа гаргана. Дайсан амьтад, аюул занал ойртох тусам хошгирах хугацаа дуугарах давтамж багасдаг.

ӨВЧИН ТАХАЛ

Монгол орны хүн амын дунд гарсан өвчлөл, тахлын голомтын олон жилийн мэдээ бүртгэл, халдвар тархах чадамж зэргийг судалсаны үндсэн дээр тахлын байгалийн голомтын үндсэн агуулагч нь “Монгол тарвага” болохыг тогтоосон байна. Монгол тарваганы дэлхэц нутгийн 55.3% тахлын байгалийн голомттой нутагт оршдог. 16 аймгийн 139 сумын нутагт 8 сая гаруй га талбай тарваган тахлын байгалийн голомттой болохыг судлаач эрдэмтэд тогтоожээ.

Тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх. Манай оронд хүмүүс тахлаар өвчлөх явдал тарвага агнуурын эрчмээс ихээхэн хамааралтай байдаг. Тахал үүсгэгч нян ахуй, агаар дуслын замаар, хоол боловсруулах эрхтнээр дамжин халдаж болохоос гадна шимэгч бүүрэгт хазуулсаны улмаас цусаар дамжин тахал өвчин халдварлана.

Монголчууд эрт дээр үеэс тахал өвчнийг мэддэг, түүний халдвараас сэргийлж ирсэн уламжлалтай. Анчид, үнэг, хярс, нохой хараад болон даллахад хошгирахгүй байгаа, бүрэн гуужаагүй, хүч тарга муу авсан, мөн нүхгүй газар тэнэж яваа тарвагыг өвчтэй хэмээн сэжиглэж агнадаггүй, шувуу барьсан хийгээд, үхсэн, агнасан тарваганы тавхайг зүсэж үзэхэд цус гарахгүй бол авахгүй хаядаг байжээ.



Тарвага хошгирч дуугарахгүй, нүхэн дээрээ удаан хэвтэж, дэмий тэнэх, муу нүхэнд орох, хөдөлгөөн харьцангуй удаан байх зэрэг шинж тэмдэг ажиглагдвал агнаж, ойртож болохгүй. Тахлын голомттой нутагт хавх, урхи, нохойгоор агнах, үхсэн буюу нохой, шувуу барьсан тарвагыг авч ашиглахыг цээрлэнэ. Тарваганы махыг гүйцэт болгож хүнсэнд хэрэглэнэ. Гэдсийг авах, өвчих, махыг нь эвдэх үед гар хуруугаа исгэх, шархтай гараар тарваганы түүхий эдтэй харьцахыг хориглоно. Эдгээр уламжлалыг сахиж мөрдөх нь тахал өвчнөөс сэргийлэх ач холбогдолтой.

Тарваганы түүхий эдтэй харьцан ажилласны дараа савантай халуун усаар гараа сайтар угааж, боломжтой бол спиртээр цэвэрлэх нь зүйтэй. Тарвагатай харьцсаны дараа халуурах, булчирхай цочих зэрэг шинж тэмдэг илэрвэл бусдаас тусгаарлан хөл хорьж, түргэн хугацаанд эмнэлгийн тусламж авах арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

Мөн тарвагатай харьцдаг хүмүүс V–VI сард тахлаас сэргийлэх вакцин тариулах нь зохилтой.

ТАРВАГА АГНУУР



XIX зууны сүүлч хүртэл голдуу цөөн малтай амьдрал тарчиг хүмүүс тарвага агнаж, арьсаар нь хувцас, эдлэл хийж, мах өөхийг нь хүнсэнд хэрэглэдэг байжээ. 1860–аад он хүртэл олноор агнаж арьсыг нь худалддаг байсан баримт олдоогүй. Дэлхийн ангийн үсний зах зээлд онцгой нөлөө бүхий Лейпциг хотын ангийн үсний мэргэжилтнүүд 1880–аад оны эхэн үед тарваганы арьсыг булга, халиу мэт үнэт ангийн үсийг дуурайлган будах болсноор зах зээлд хямд үнэлэгддэг байсан тарваганы арьсны үнэ эрс өссөн. Ийнхүү арьсны үнэ огцом нэмэгдсэн нь агнуурын арвин нөөцтэй Монгол түүний хил залгаа нутагт тарвага агнуур эрчимжих үндсэн шалтгаан болсон юм.

Монголоос Өргөө, Хиагт, Ховдын хязгаараар гаран Орос, Хятадад худалдаалсан арьсны мэдээ баримтаас түүвэрлэн үзэхэд, 1865 онд баруун Монголоос 30 мянган арьс, 1922–1931 онд 16 сая орчим арьсыг хил нэвтрүүлсэн тухай дурьдсан нь тэр үед агнан олборлож, гадаад дотоодын хэрэгцээнд ашигласан бүрэн хэмжээний мэдээ бус гэдэг нь тодорхой билээ.

Харин 1930–аад оноос арьсыг төлөвлөн бэлтгэх, борлуулах эрхийг улсын мэдэлд авснаар арьсны тоо

хэмжээг харьцангуй бодитой бүртгэх болсон. Монгол орон тарвага агнуурын түүхэндээ хамгийн их 4 сая шахам арьсыг 1910 онд, дэлхийн 2–р дайны дараа 1946–1955 онд дунджаар жилд 2.3 сая тарваганы арьс бэлтгэсэн мэдээ бий. Тарвага агнуур эрчимжсэн XIX зууны сүүлчээс XX зууны сүүлч хүртэл 100 гаруй жилд 150 сая орчим арьс улсад бэлтгэсэн тооцоо гарч байна.

Ийнхүү олон жил дараалан хайр гамгүй, тооцоо судалгаа муутай агнаснаас үүдэн, ихэнх нутагт хэвийн үржил, нөхөн төлжилт, популяцийн зөв бүтэц алдагдаж, тархац нутаг тасархайтан хумигдаж, тоо толгой, нөөц эрс багасан зарим нутагт устаж үгүй болжээ.



ТАРВАГАНЫ БАЯЛАГИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ



Монголчууд тарваганы арьс, тосыг ахуйн хэрэгцээнд, мах өөхийг хүнсэнд, дотор эрхтэн, тосыг элдэв өвчнийг анагаахад, соёог гоёл чимэглэл хийхэд, ходоод, мах чанасан шөлийг ядарч доройтсон малыг тэжээн тэнхрүүлэхэд ашигладаг уламжлалтай.

Агнуурын үеийн нас бие гүйцсэн нэг тарваганаас арьс, олон тооны амин хүчил, тэжээлээр баялаг 2.3–3.5 кг мах, 320–520 гр дотор, 480–720 гр гадар өөх, 250–300 гр хүртэл цэвэр тосыг ялган ашиглаж болно. Тарваганы амт шим, шингэц сайтай, уураг, тос, А, Д, Е амин дэмээр баялаг мах, өөхийг Монголчууд хүнсэнд хэрэглэх явцдаа тухайн нутаг орны уур амьсгал, Монгол хүний бие организм, нүүдлийн ахуйд зохицсон төрөл бүрийн хоол хүнс бэлтгэх жор технологийг боловсруулсан.

Тарваганы өөхийг хүнсэнд хэрэглэхээс гадна тосыг хүний биед гэмтлээс үүссэн элдэв шарх, хөлдөлт, түлэгдэлт, сүрьеэ, судас хатуурах, малын цахлай өвчнийг эмчлэхэд өргөн хэрэглэнэ. Түүнчлэн арьс ширний болон, үнэртний үйлдвэрлэлд ашиглах боломж буйг судлаачид тэмдэглэдэг.

МОНГОЛ ТАРВАГА СЭРГЭЭН НУТАГШУУЛСАН ТУРШЛАГА

Монгол орны хээрийн экосистем бүрэлдэн тогтох, тогтвортой хадгалагдахад зайлшгүй чухал нөлөөтэй амьтдын нэг нь монгол тарвага юм. Монгол тарваганы тархац, байршил, нягтшилаас бусад олон зүйл амьтдын тархац, байршил, хам амьдралын хэвийн үйл ажиллагаа, ургамлын зүйлийн бүрдэл, хөрсний механик бүтэц хүртэл хамаарах онцлогтой.

Олон жил дараалан хайр гамгүй, тооцоо судалгаа муутай агнасан болон байгаль цаг уурын тааламжгүй хүчин зүйлээс үүдэн, ихэнхи нутагт тарваганы хэвийн үржил, нөхөн төлжилт, бүлийн зөв бүтэц алдагдаж, тархац нутаг тасархайтан хумигдаж, тоо толгой, нөөц эрс багасан зарим нутагт устаж үгүй болсон тухай бид өмнө дурьдсан. Сүүлийн жилүүдэд нутгийн ард иргэд, байгаль хамгаалагчид, судлаач, эрдэмтэд, олон улсын төсөл, хөтөлбөрийн санаачлагаар Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлууд хийгдсэн.





“Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төсөл, “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн санхүүжилтээр 2016 оны зун Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо сумдын 2 цэг нутагт нийт 117 бодгаль монгол тарвагыг сэргээн нутагшуулах ажлыг судлаач, эрдэмтэд, нутгийн иргэд, байгаль хамгаалагчид, төслийн удирдлагатай хамтран амжилттай хийж гүйцэтгэлээ.

Нийслэл хотын ногоон бүсэд газар ашиглах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, ашиглалтын талбайд нягтшил өндөртэй байршин амьдрах монгол тарвагыг амьдаар барьж, тарвага ховордсон, зүүн бүс нутгийн тодорхой цэг нутгуудад сэргээн нутагшуулах нь нэгэнт амьдрах орчин нь антропогенийн хүчин зүйлийн шууд нөлөөлөлд өртөж хязгаарлагдан цаашид тоо толгой нь өсөн нэмэгдэх, тархац нутгаа тэлэх боломжгүй болсон жижиг тасархай популяцид авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай хамгааллын төдийгүй байгалийн голомтот халдварт тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болсон юм.

Тус бүс нутагт тарвага сэргээн нутагшуулах явцад нутгийн иргэдийн нөхөрлөлүүдэд нутагшуулсан тарвагыг хариуцуулсан бөгөөд, идэвхтэн байгаль хамгаалагч нар байнгын ажиглалт судалгаа хийх, хууль бус агнуур бүртгэгдсэн тохиолдолд сумын болон төслийн ажилтнуудад мэдээлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулав. Үүний үр дүнд дээрх 2 суманд зөвхөн тарвага нутагшуулсан газар нутагт 2016 онд 130 хавх хураан авч, нэлээдгүй зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтнаар арга хэмжээ авахуулсан байна.

Тарвага сэргээн нутагшуулсан дээрх нутагт тарваганд дайсагнагч махан идэшт амьтдын тоо харьцангуй цөөн, зуншлага сайжирч идэш тэжээлийн хүрэлцээ хангамж нэмэгдсэн, нөхөрлөлийн гишүүд тухайн популяцийг хариуцлагатай харж хандан, тогтмол ажиглаж, золбин нохойг устган өөрсдийн нохойг хараа хяналтандаа байлгаж, малын бэлчээрээс аль тарваганы эзэмшил нутгийг сул чөлөөтэй байлган, тарвага тарга хүчээ бүрэн авснаас хойш буюу ичээнд орсноос хойш тухайн бэлчээрийг ашиглах зэрэг арга хэмжээ авахыг зөвлөсний дагуу ажиллаж байгаа нь тухайн газарт тарвага амжилттай сэргэн нутагших таатай нөхцөл бүрдэж байна хэмээн үзэж болох юм.

Тарваганы баялагыг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг зөв шийдвэрлэхэд үржлийн онцлог, нөхөн төлжих чадавхи, үхэл хорогдлын шалтгааныг бүлийн нас, хүйс, тоо толгой нягтшилтай нь холбон нарийвчлан тогтоох нь чухал ач холбогдолтой.

Сэргээн нутагшуулсан багийн эрдэмтдийн олон жилийн туршлага, судалгааны материалд тулгуурлан урьдчилан тооцоолж байгаагаар экологи биологийн болон хүний сөрөг үйл ажиллагааны нөлөө бага таатай нөхцөлд сэргээн нутагшуулснаас 3–5 жилийн дараагаар эхний үр дүнгүүд гарч ахуйн зориулалтаар цөөн тоогоор агнах боломж бүрдэж, 8–10 жилийн дараа үйлдвэрлэлийн зориулалтаар агнан олборлох нөөцтэй болох тооцоо судалгааг хийлээ.

Өнгөрснийг буруутгах биш ирээдүйг харж боломжийг зөвөөр тодорхойлж голомт нутагтаа ховордсон, устсан аливаа ан амьтныг хуучин тархац нутагт сэргээн нутагшуулах нь ан амьтан, байгаль хамгааллын зайлшгүй чухал үйл ажиллагааны нэг мөн.

ТАРВАГА ХАМГААЛАХ УЛАМЖЛАЛ

Монголчууд эрт дээр үеэс ан амьтдыг хамгаалах, зохистой ашиглахыг эрхэмлэн энэ харьцааг тухайн цаг үеийн онцлогт тохирсон хууль журам боловсруулан чанд мөрдөн зохицуулж байсныг Чингисийн их засаг, Халх журам, Алтан хааны хууль зэрэг алдарт сурвалж бичгүүд, Үндсэн хууль, эрх зүйн бусад баримт бичигт

залгамж чанартайгаар тусган хэрэгжүүлж ирснийг үзэж болно. Тухайлбал 1640 оны “Их цааз”-ын бичигт “..... тарвага утаад ухаж авалгүй орхисон хүнээс шүдлэн үхэр ав”, гэх буюу XVI зууны II хагасын “Зургаан хошууны хууль цаазын бичиг”-т “... хэн хүн адгуус амьтдыг шаналган алах”-ыг хоригложээ.

Автономит Монголын засгийн газраас 2–3 жил тарвага агнахыг эс зөвшөөрсөн тухай тушаал гаргаж, сүм хийдэд тарваган дээл, хувцастай хүн орох, махаар нь элдэв янзын хоол хийхийг хүртэл хориглож байсан. Энэ нь нэг талаар тарваганы нөөцийг хамгаалж, нөгөө талаар тухайн үедээ эмчлэн анагааж чадахгүй олон хүний амь насыг сүйтгэж байсан тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ байжээ. 1926, 1934 оны ан агнах, загас барих дүрэм, хуульд ан агнах арга хэрэгсэл, хугацааг тодотгож, зарим ан амьтад, түүний дотор тарвагыг IV сараас VIII сарын 01 хүртэл агнахыг хориглосон. Ийнхүү төр засгаас тарваганы түүхий эдийг зөв зохистой ашиглах, ангийн нөөц, тарваганы баялагыг хамгаалах зорилготой шат дараалсан олон чухал арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлж иржээ.

Монголын нийгэм эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжиж эхэлсэн 1990–ээд оноос тарвага агнуурт өргөн хэрэглэдэг бага калибрийн буу, сум элбэгшиж, худалдан авах, ашиглалт, зарцуулалтад тавих хяналт эрс суларлаа. Сүүлийн жилүүдэд ан авын туршлага дадлага багатай хүмүүс тарвага агнаж шархдуулах, нүхэнд алах, мөндөл агнах, урхиар барих, хуулийн бус хугацаанд ялангуяа үржлийн үед нь агнах явдал эрс ихэслээ. Дээрх үйлдэлүүд нь тахал дэгдээх аюулыг дагуулдаг төдийгүй ийнхүү хайр гамгүй, тооцоо судалгаагүй, нөхөн үржих чадавх, нас, хүйс харгалзахгүйгээр агнаж байгаа нь тоо, толгой, нөөц хомсдох үндсэн шалтгаан болж байна.

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ



Тарвагыг ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар агнахад анчид, сонирхогчид зайлшгүй мэдэж, дагаж мөрдөх ёстой хууль эрх зүйн холбогдолтой зарим асуудлыг товч дурдъя.

Монгол улсын “Үндсэн хууль” –д заасны дагуу аливаа ан амьтан төрийн өмч бөгөөд хамгаалах, зохистой ашиглахтай холбогдсон харилцааг Үндсэн хууль (1992), Амьтны тухай хууль (2012) болон эдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Аливаа зориулалтаар тарвага агнах, барих иргэн Амьтны хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй, ангийн буу эзэмших эрхийн үнэмлэхтэй, ангийн бууны албан татварыг төлсөн, улсын бүртгэлд хамрагдсан, тарваган тахлаас урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн байх нь зүйтэй.

Ахуйн зориулалтаар тарвага агнах иргэн нь тухайн төрийн захиргааны байгууллагаас “Ан агнах, загас барих эрхийн бичиг” олгох эрх олгосон албан тушаалтанд зохих хураамжийг төлж эрхийн бичигт заасан тооны тарвагыг дурдсан газар, хугацаанд Амьтны тухай хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгслэлээр агнана.

Хот тосгоны оршин суугч иргэн ахуйн зориулалтаар “Ан агнах, загас барих эрхийн бичиг” –ийн хүрээнд 3 хоногт багтаан 5 хүртэлх тооны тарвагыг агнаж болно.

Амьтны тухай хууль тогтоомж, тушаал шийдвэрийг зөрчин тарвага агнах, барихыг завдсан, агнасан, барьсан, түүний гаралтай түүхий эдийг худалдсан, худалдан авсан этгээдэд зөрчлийн агуулгыг харгалзан хуульд зааснаар иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1–3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, хуулийн этгээдийг 3–45 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, албан тушаалтанг 4–15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгуулаар тус тус торгож, амьтны аймагт учруулсан хохирлыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор батлагдсан “Ан амьтны экологи–эдийн засгийн үнэлгээ” –г 2 дахин өсгөн нөхөн төлүүлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Та Монгол улсын амьтны тухай хууль зөрчиж тарвага агнавал дараах торгууль, шийтгэл хүлээж болно.

| № | Амьтны тухай хуулийн заалтууд | Торгуулийн хэмжээ (мян.төг) | |
|----|--|---|--------------------------|
| | | Иргэн | Аж ахуй нэгж байгууллага |
| 1 | Х/16–VIII/20 хүртэлх хугацаанд тарвага агнавал (9.1.3) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 2 | Хугацаа дуссан зөвшөөрлөөр агнах, ангийн буу, эрхийн бичиг тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлбэл (39.1.4) | ХХДХ • 1 | ХХДХ • 3 |
| 3 | Зохих гэрээ, эрхийн бичиг, зөвшөөрөлгүй ахуйн болон тусгай зориулалтаар агнасан, барьсан бол (39.1.9) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 4 | Зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих (39.1.10) | ХХДХ • 3 | ХХДХ • 45 |
| 5 | Зохих гэрээ, эрхийн бичигт зааснаас хэтрүүлэн агнавал (39.1.7) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 6 | Агнахыг түр хориглосон газраас буюу хот, тосгоны ногоон бүсээс тусгай зөвшөөрөлгүй агнавал (11.1.10) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 7 | Утах, ус цутгах, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах аргаар агнавал (10.1.4) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 8 | Зориулалтын бус буугаар агнавал (10.1.8) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 9 | Байгалийн гамшигт нэрвэгдсэн (ган, үер ус) үед агнавал (11.1.1) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 10 | Ичээ нүхийг ухаж гэмтээвэл (11.1.4) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 11 | Мөндөл агнавал (11.1.7) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 12 | Тарваганы түүхий мах, нойтон арьсыг хот тосгонд оруулбал (11.1.9) | ХХДХ • 2 | ХХДХ • 5 |
| 13 | Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг дагалдах тодорхойлолтгүй худалдсан, худалдан авсан тохиолдолд (37.3) | Ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж нөхөн төлбөр ноогдуулна. | |

*ХХДХ – Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэн танд доорх урамшуулал олгогдоно:

Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн засаг дарга олгоно.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ИРГЭНИЙ ЭРХ

1. Гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах
3. Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх
4. Холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах
5. Байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргах болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах
6. Сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтанд орж, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ИРГЭНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ


1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх
2. Байгаль орчныг хамгаалах үндсэний уламжлал, зан заншил эзэмших хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох
3. Байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх
4. Байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэнэ.





ИДЭВХТЭЙ БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДАД

МОНГОЛ ТАРВАГАНЫ МОНИТОРИНГ СУДАЛГАА

Мониторинг судалгаа гэдэг нь хүн ба байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хүрээлэн буй орчин, экосистем, амьтан ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгдөх үйл явцад урт хугацааны турш

 Ажиглалт хийх

 Үнэлэлт өгөх

 Урьдчилан таамаглах зэрэг цогц үйл ажиллагаагаар тандан судлах үйл явцыг хэлнэ


Мониторинг судалгааг хамрах цар хүрээгээр нь орон нутаг, бүс нутаг, тив дэлхийн гэж ангилна. Судалгаа нь дахин давтагдах шинж чанартай байх бөгөөд тухайн мэдээнд дүгнэлт хийхийн тулд уг судалгааг олон удаагийн давтамжтай хийх шаардлагатай. Эхний удаагийн судалгаа бодит дүгнэлтийг хийхэд хангалтгүй байдаг.


Мониторинг судалгааг явуулахын тулд байгаль хамгаалагч нар тооллого судалгаа явуулах арга зүйг эзэмшиж, хариуцсан нутагтаа ан амьтны тооллогыг дэлхэц нутгийг бүрэн хамруулан хийж чадвал тухайн зүйлийн тархац, тоо толгой, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодруулах бүрэн боломжтой.


Иймээс тогтсон судалгааны аргазүйн дагуу, урт хугацаанд хийсэн судалгаа нь бүрэн төгс дүгнэлт хийх, түүнд түшиглэсэн оновчтой менежментийг хэрэгжүүлэх боломжийг олгоно.


ЗЭРЛЭГ АМЬТНЫ МОНИТОРИНГ СУДАЛГАА ХИЙХ АЧ ХОЛБОГДОЛ

Зэрлэг амьтны хамгааллын менежментийг үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд бид дараах зүйлсийг мэдэж байх шаардлагатай. Үүнд:

 Тухайн нутагт ямар зүйлийн амьтад тархдаг болох

 Эдгээр зүйл амьтад хичнээн тоо толгойтой байгаа

 Тухайн зүйл амьтан хаагуур тархан байршдаг

 Жилийн аль улиралд илүү идэвх, шилжилт хөдөлгөөнтэй болох зэрэг болно.

Эдгээр мэдээллүүд нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, зэрлэг амьтан хамгааллыг сайжруулах, зэрлэг ан амьтны нөөцийг зохистой ашиглах, тэдгээрийн амьдрах орчинг хамгаалахад тустай, үнэ цэнэтэй эх хэрэглэгдэхүүн болно.

Өргөн утгаар нь авч үзвэл эх орны өнцөг булан бүрт байгаа иргэн, байгаль хамгаалагч нэг бүрийн үүрэг, оролцоон дээр тулгуурлан зохистой ашиглах, хамгаалах ажлуудын төлөвлөлт хийгдэнэ гэсэн ойлголт болно.

Доорх үндсэн мэдээллийг тогтмол хугацаанд, тогтоосон аргазүйн дагуу урт хугацааны турш өргөн уудам газар нутгийг хамруулан бүрдүүлж чадвал хамгаалалттай газар нутаг хийгээд бүс нутгийн түвшинд зэрлэг амьтны хамгааллын оновчтой бодлого боловсруулан хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Тухайлбал. Тухайн бүс нутаг, хамгаалалттай газарт тархсан амьтдын зүйл тус бүрийн тоо толгойн байдал,


нас хүйсийн харьцаа, нөөц, түүнд нөлөөлөгч махчин амьтдын тоо, нөөцийн талаарх мэдээлэл бүрдүүлэх. байршил, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх хүчин зүйлс болох бэлчээр, усны нөөц, ашиглалт түүнтэй холбогдон гарах абиотик хүчин зүйлс тухайлбал өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, худаг, барилга байгууламжийн холбогдолтой мэдээллийг бий болгох шаардлагатай.

СУДАЛГААНД ХЭРЭГЛЭХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ

Хээрийн судалгаанд нутгийн талбайн хэмжээнээс хамааран янз бүрийн масштаб бүхий газрын зураг, дуран, байршил тогтоогч, телескоп, гэрэл зургийн аппарат зэрэг багаж хэрэгслэлээс гадна бүртгэлийн тусгай дэвтэрт тарваганы тархац, байршил, тоо, нягтшил, нөөцийн холбогдолтой газарзүй, ландшафт, экологи онцлогийн боломжит бүх мэдээллийг бүртгэн тэмдэглэнэ.


СУДАЛГААНЫ ДЭЭЖ ТАЛБАЙ, ЗАМНАЛ СОНГОХ


Судалгааны хийх талбайг сонгохдоо санамсаргүй байдлаар буюу амьтны нөөц, тархцын цөм нутгаас үл хамааран нийт тархац нутгийг хамруулан системчилсэн байдлаар сонгоно. Судалгааны талбай болон замналыг сонгохдоо дараах хэд хэдэн хүчин зүйлсийг тооцож үзэх шаардлагатай.


 **Судалгаа хийх газар нутаг:** Судалгаа хийх талбайн хэмжээг судалгааны зорилго, зорилтот зүйл амьтны тархац, байршилд үндэслэн тооцох хэрэгтэй.

 **Мониторинг судалгаа хийх нөөц, чадавхи:** Хүний болон техникийн нөөц, бололцоо,

чадавхийг буюу нийт байгаль хамгаалагч, идэвхитэн болон судалгаанд байнга оролцох хүний тоо, судалгааг гүйцэтгэхэд хэрэглэх морь, машин, техник хэрэгсэл гэх мэт бусад нөөц.

 **Ургамалжилтын хэв маяг:** Тухайн судалгааны бүс нутгийн ургамалжилтын онцлогийг харгалзан үзнэ. Хялганат хээр, бут, сөөг бүхий цөлөрхөг хээр, харгана, заг, шаваг, хармагийн сондуул гэх мэт...

 **Байгалийн нөхцөл:** Тал газар, уулархаг, аараг толгодтой, жалга ихтэй уулын хөндий гэх мэт...

 **Тухайн зүйлийн төлөв:** Нүүдлийн, суурьшмал, том эсвэл жижиг сүрэг үүсгэдэг гэх мэт хүчин зүйлсийг тооцож судалгааны замналыг санамсаргүй байдлаар, системчлэн, судалгааны талбайг бүрэн хамарсан байдлаар сонгох хэрэгтэй.

Тарвага тоолох хэд хэдэн арга бий. Манай орны нөхцөлд хамгийн тохиромжтой нь талбайн болон замналын арга юм.

Талбайн арга. Тооллого явуулах газрын гадаргуугаас шалтгаалан дээж талбайг янз бүрийн хэмжээтэй сонгож болно. Ихэвчлэн 5–30 га /500x100 м, 250x200 м/ талбайг сонгоно. Тарваганы тооллогыг хийхдээ тарваганы идэвхтэй үе буюу өглөө, оройны гараанаар хийж гүйцэтгэнэ. Тухайн сонгон авсан талбайн тарваганы идэвхтэй бэлчих үйл хөдлөлд саад болохооргүй өндөрлөг цэгээс хоёр нүдний дуран, телескопоор ажиглаж тухайн талбай дахь бүлийн тоог тодорхойлон гаргана. Үүний дараа тарвага тоолсон

талбайг 100 га буюу 1 км.кв талбайд шилжүүлэн тооцоолж тархац нутгийг ховор (1 км.кв –т 10–с дээшгүй), дунд зэрэг (1 км.кв –т 11–30), элбэг (1 км.кв –т 31–с дээш) бүлийн нягтшилтай гэж хуваан бодгаль тус бүрийн насны (мөндөл, хотил, шар хацар, бие гүйцсэн) ялгаа, бүлийн тоог тодорхойлж тусгай хүснэгтэд бүртгэнэ (1–р хавсралт). Энэ ажиглалтыг гүйцэтгэснээр тухайн нутгийн тарваганы тоо, нягтшил, бүл, бүлийн насны бүтэц, үржлийн биологийн чадавхийг тодорхойлох чухал мэдээ хэрэглэхүүн цуглуулж чадна.

Шугаман замналын арга. Энэ арга зүйг тэгш, тэгшивтэр гадаргуутай, тарваганы тархцын хүрээ өргөн нутагт хэрэглэхэд илүү тохиромжтой. Тарваганы тархац нутаг дундуур 1–5 км урттай замналаар

явж 100–200 м өргөн зурвас дахь тарваганы бүл, тарваганы тоо, толгойг тодорхойлно (1–р хавсралт). Ингэхдээ замналыг аль болох шулуун хийх шаардлагатай. Энэ аргыг дээж талбайн аргаар тооллого явуулсан газар нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор тарваганы нүхний байршил (уул толгодын ар, хажуу энгэр бэл, гуу жалга гэх мэт...) тоог, ичээ, зусаал, муу нүхээр ялгаж байршлыг зурагт тэмдэглэн бүртгэхэд хэрэглэнэ. Маршрутын урт болоод өргөн бага хэмжээтэй байх нь цуглуулсан мэдээлэл бодит байдалд дөхүү гардаг болохыг анхаарна уу!

Уг мэдээлэл нь тухайн нутгийн тарваганы тоо толгойн байдал өсөж, буурч байгаа эсэх, популяцийн менежментийг үнэлэхэд чухал ач холбогдолтой.

МОНГОЛ ТАРВАГАНЫ МОНИТОРИНГ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ХҮСНЭГТ

| Газрын нэр: | | | | | | | | | | | | | | |
|---|-------|-----|---------|--------|--------------|-----------------------------|------|-------------|-------|--------|-------------|---------|-------|---------|
| Амьдрах орчин: | | | | | | | | | | | | | | |
| Замналын дугаар: | | | | | | | | | | | | | | |
| Ажиглагчийн нэр: | | | | | | | | | | | | | | |
| Замналын чиглэл, эхлэл төгсгөлийн солбицол: | | | | | | | | | | | | | | |
| Нийт замналын урт, өргөн: | | | | | | | | | | | | | | |
| № | Огноо | Цаг | Өргөрөг | Уртраг | Өндөршил /м/ | Тарвага болон түүний ул мөр | Нийт | Бие гүйцсэн | Хотил | Мөндөл | Тодорхойгүй | Зай /м/ | Өнцөг | Тайлбар |
| 1 | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | | |

НОМ ЗҮЙ

Адъяа Я. Монгол тарвага. Биологи экологи хамгаалал аж ахуйн холбогдол. Улаанбаатар. 2000. х. 199,

Адъяа. Я. Ичээний амьтдын нууц тайлагдсаар ... // Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл 1984. Х 60–61

Адъяа Я. Амьтдын зан төрх ба феромон // Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. 1987. Х.35–37

Адъяа. Я. Монгол тарваганы арьсны бүтцийн тухай зарим мэдээ // Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл . 1986. Т.21. с.23–25

Адъяа. Я. Тарваганы баялагыг зохистой ашиглах асуудалд // Үнэн сонин. 1988. № 202.

Адъяа.Я. Кожный покров монгольского сурка // Отв. редактор О.Ф.Чернова, Москва–2007, –114 с. Биологические ресурсы и природные условия Монголии; Труды Совместной Российско,– Монгольской комплексной биологической экспедиции; Т.47

Адъяа. Я. Промысел сурков в Монголии // III International Conference on Marmots “Holarctic marmots as a factor of biodiversity” Cheboksary, Chuvash Republic, Russia 25–29 August, 1997. P.7–8

Банников А.Г. Млекопитающие Монгольской Народной Республики // Тр.Монг. комиссии. Вып. 53 – М.: АН СССР,1954 (а) 669.С

Банников А.Г. Сурки Монголии // Уч.Зап. Моск.гор. пед. ин–та им. В.М.Потемкина, 1954, т.28, вып.2, с.257–303.

Батболд Ж. Батсуурь.Ж. Монгол тарваганы популяци дахь тахлын эпизоотийн шинж чанар. МУҮИС–ийн эрдэм шинжилгээний бичиг. Биологийн салбар,1995. №.1.(115) 109–141 х.

Бибиков Д.И. Горные сурки средней Азии и Казахстана. М.: Наука, 1967, 198.С

Бибиков Д.И. Сурки // М.: Агропромиздат, 1989, 255.С

Бибиков Д.И., Мягмаржав Д. Тарбаган и тарбаганий промысел в МНР // Охота и охотничье хозяйство, 1980, N 7, с.42–43.

Бибиков Д.И., Мягмаржав Д. Опыт картографирования и оценки ресурсов сурков в МНР // Сб. Охрана и рациональное использование и экология сурков. Мат. Всесоюз.сов., М.: 1983, с.22–26.

Бибиков Д.И., Мягмаржав Д. Стратегия использования ресурсов тарбагана в Монгольской Народной Республике // Природные условия и биологические ресурсы МНР. Тез.докл. междунар.конф., М.:1986, с.123–124.

Бибиков Д.И., Мягмаржав Д., Поле С.Б., Смирин Ю.М. Хангайский тарбаган /M. bobac caliginosus/, размещение, ресурсы, экология // Зоол. журн., 1990, т.69, вып.5. с.100–107.

Бибиков Д.И., Поле С.Б., Смирин Ю.М., Мягмаржав Д. Размещение и ресурсы сурков Монгольского Алтая // Зоол.журн., 1987, т.66, вып.9, с.1375–1387.

Бүдсүрэн.Ч. Монгол тарвага (Marmota sibirica)–ны бүл, колонийн эзэмшил нутгийн бүтэц, ашиглах байдал // ЕСБХ байгуулагдсаны 30 жилийн ойд зориулсан э/ш–ний бага хурлын илтгэлүүдийн хураангуйн эмхтгэл, УБ.1996. х.43

Машкин В.И., Батурин А.Л. Сурок Мензбира / НИИОЗ им. Проф. Б.М.Житкова, Киров, 1993. 140.С

Эрэгдэндагва Д. Тарбаган и его хозяйственное значение в МНР. Автореф. дисс. канд. биол. наук.– Иркутск.,1959. 19.С



www.mpa.gov.mn



НАРУД ДИЗАЙН ХХК
Утас: 91090506, 86063737